

Сэлэнгийн Жид голын хөндийд тархах Дагуурын нугажуу хээрийн зарим өвөрмөц бүлгэмдлийн тухай (Буриад – Монгол)

Намзалов Бимба-Цырэн Батомункуевич^{1*}, Индрээгийн Тувшинтогтох², Намзалов Максар Бимба-Цыренович¹

1Буриадын Улсын Их Сургуулийн Ботаникийн тэнхим, Улаан-Үүд, ОХУ
2Шинжлэх Ухааны Академи, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, Улаанбаатар 13330, Монгол Улс

*И-мэйл: namzalov@rambler.ru

<https://doi.org/10.5564/mjb.v7i33.5388>

Хураангуй: Буриадын өмнөд хэсэг болон Монголын умард хэсгийн Сэлэнгийн дундаж уулс бүхий нутаг нь Амарын сав газартай хиллэн оршдог ба ургамлын аймгийн мужлалаар Голарктикийн их муж, Зүүн Азийн дэд их мужийн Дагуур-Манжуурын хошуунд багтдаг. Амарын сав газраар дамжин Номхон дөлгөөн далайн муссон (далайн чийглэг зөөлөн уур амьсгал)-ы нөлөө Сэлэнгийн Дагуур хүргэл эх газрын гүн рүү нэвтрэн хүрдэг. Энэ нь Сэлэнгэ мөрний цутгал голууд болох Хилок, Чикой, Жидын ургамалжлын баялаг олон янз байдлаар илэрнэ. Жид голын хөндийн доод урсгалд өндөр өвст нугажуу хээрийн бүлгэмдлүүд хэсэгчлэн тэмдэглэгдсэн бөгөөд Сэлгэр, Зэлтэр, Алцак хэмээх гурван ландшафт-ургамалжил бүхий газраар төлөөлөгддөг. Нугажуу хээрийн онцлог зүйлүүдэд *Vupleurum scorzonifolium*, *Scabiosa comosa*, *Filifolium sibiricum*, *Lespedeza davurica*, *Saposhnikovia divaricata*, *Lilium pumilum*, *Delphinium grandiflorum* зэрэг орно. Бидний бичиглэл хийсэн Жидийн нугажуу хээрийн гурван бүлгэмдэлд нийтдээ 71 зүйлийн гуурст ургамал бүртгэгдсэн бөгөөд эдгээрийн дөрөвний нэг буюу 25,3%-ийг алаг өвс эзэлж, үүний дотор Зүүн Азийн болон Дагуур-Манжуурын гаралтай зүйлүүд 89,0%-ийг эзэлж байна. Дагуурын нугажуу хээрийн ургамлын ийм баялаг генефонд нь ялангуяа эмийн ургамлын баялгаар илэрхийлэгдэж байна.

Түлхүүр үгс: Сэлэнгийн Дагуур, нугажуу хээрийн бүлгэмдэл, эмийн ургамал

Эшлэл авахдаа: Намзалов Бимба-Цырэн Батомункуевич^{1*}, Индрээгийн Тувшинтогтох², Намзалов Максар Бимба-Цыренович¹ 2025. Сэлэнгийн Жид голын хөндийд тархах Дагуурын нугажуу хээрийн зарим өвөрмөц бүлгэмдлийн тухай (Буриад – Монгол). Монголын ботаникийн сэтгүүл, 07(33): 160-171.


Удиртгал

“Дагуурын өндөр өвст нугажуу хээр-прери” хэмээх ургамлын аймаг-ургамал бүлгэмдлийн хэвшинж (флороценотип)-ийг анх Р.В.Камелин 1987 онд Оросын Ботаникийн сэтгүүлд Монгол орны ургамалжлын тойм өгүүлэлдээ тодорхойлон бичжээ (Камелин, 1987).

Дараа нь 2002, 2010 онд Р.В.Камелин энэ сэдвийг дахин хөндөж, “Өмнөд Сибирь ба Монгол орны ботаникийн асуудлууд” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл болон “Turczaninowia” сэтгүүлд хоёр

сонирхолтой бүтээл нийтэлжээ (Камелин, 2002, 2010). Эдгээр бүтээлд зохиогч Дагуурын нугажуу хээрийн статусыг нэлээд өргөжүүлж, Голарктикийн их мужийн Зүүн Азийн дэд их мужийн Хятад-Японы мужид харьяалагдах Дагуур-(Монгол)-Манжуурын өвөрмөц хошууг ялган тодорхойлсон бөгөөд үүнд Сэлэнгэ-Дагуурын тойргийг багтаан, дотор нь 5 районд хуваажээ. Үүнд: Монгол орны Сэлэнгийн савд 2(3), үлдсэн нь Буриадын нутагт хамаарагдана (Зураг 1).

Амар мөрний сав газрын дагуух нутгийн Зүүн Азийн элементүүдийн тархацын судалгаагаар гурван бүсийг тодорхойлон гаргаж байна. Үүнд: үндсэн, идэвхтэй, захын. Захын бүс нь Амарын сав газарт харьяалагдахгүй ба Байгал нуурын сав газарт орших Сэлэнгийн Дагуурыг хамарна. Дунд хэсгийн идэвхтэй бүсэд Зүүн Азийн болон Манжуур-Дагуурын зүйл ургамлын эзлэх хувь өндөр бөгөөд 70–85% хүрдэг. Энэ бүсийн онцлох зүйлүүдэд *Paeonia lactiflora*, *Ulmus macrocarpa*, *Sophora flavescens*, *Scutellaria baicalensis*, *Aster maackii* зэргийг дурдаж болно. Харин үндсэн бүсэд муссон шууд нөлөө үзүүлэх эх газрын хэсэг хамрагдана (Шатилина, Анжина, 2011). Энд өндөр чийгшил бүхий нөхцөл бүрэлдсэнээр шилмүүст-өргөн навчит ой, нуга-намгийн ургамалжлын хэвшинж давамгайлах нөхцөл болдог. Энэ бүсийн ургамлын аймгийн онцлог төлөөлөгчид нь: *Tilia amurensis*, *Acer mono*, *Ulmus laciniata*, *Securinega suffruticosa*, *Euonymus sacrosanta*, *Zizania latifolia*.

Амур мөрний сав газар — эх газар (Зүүн Сибирийн өмнөд)-аас Номхон дөлгөөн далайн эрэг хүртэл			
Бореалын дэд их мужийн хошуу: 2 – Алтай-Саяны; 3 – Байгал-Зүүнгарын; Азийн дэд их мужийн хошуу: 7 – Дагуур-Манжуурын; 8 – Амарын; 9 – Хойд Хятадын; 10 – Дорнод Монголын (Камелин, 2010).			
	М у с с о н ы нөлөөллийн түвшин, %		
Алс Дорнодын муссон нөлөөлөх бүс нутгууд			
	Захын бүс	Идэвхтэй бүс	Үндсэн бүс
	5-15% (15)	50-85% (90)	80-90% (100)
М у с с о н ы нөлөөллийг тодорхойлох ургамлын онцлог зүйлс	<i>Bupleurum scorzonerifolium</i> , <i>Filifolium sibiricum</i> , <i>Scabiosa comosa</i> , <i>Lespedeza davurica</i> , <i>Lilium pumilum</i>	<i>Clematis hexapetala</i> , <i>Scutellaria baicalensis</i> , <i>Allium spirale</i> , <i>Paeonia lactiflora</i> , <i>Quercus mongolica</i> , <i>Platycodon grandiflorum</i> , <i>Aster maackii</i>	<i>Tilia amurensis</i> , <i>Acer mono</i> , <i>Ulmus propinqua</i> , <i>Securinegra suffruticosa</i> , <i>Euonymus sachalinensis</i> , <i>Zizania latifolia</i>

Зураг 1. Амар мөрний сав газрын дагуу муссоны ургамлын аймгийн зүйлийн бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөө

Өвөр Байгал дахь Сэлэнгийн Дагуурын захын бүсийн байршил нь түүний ургамлын аймаг, ургамалжилд тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлэх бөгөөд энэ нь Алс Дорнодын муссоны нөлөөлөлд орших өөр өөр секторуудын маркер зүйлстэй харьцуулснаар илэрдэг (Зураг 1, 2).

Ялангуяа «Дагуур-Манжуурын нугажуу хээрийн сектор» гэж нэрлэгддэг бүсийн ургамалжил одоогоор хангалттай судлагдаагүй хэвээр байна (Камелин, 2010).

Амарын сав нутгийн Дагуурын хэсгийн ургамалжлын онцлогийг судлахад А.В.Галанин болон түүний шавь нарын (Галанин, Беликович, Храпко, 2008; Галанин, Беликович, 2012) олон бүтээлүүд чухал хувь нэмэр оруулсан. Үүнээс өмнө Б.Н.Колесников (1955), Г.Э.Куренцова (1962) нар Манжуур болон Хянганы нуруу хүртэлх алаг өвсний оролцоо өндөр нугажуу хээрийн өвөрмөц онцлогийг тэмдэглэж байсан. В.Б.Сочава Амарын хээрийн ургамалжлыг “степпоид” гэж нэрлэсэн (Сочава, Липатова, 1960). А.Ю.Корольок (2002) Дагуур-Манжуурын хэвшинжийн нугажуу хээрийн ургамлын аймгийн өвөрмөц байдлыг харгалзан ангиллын бие даасан нэгж болгон авч үзэх шаардлагатайг тэмдэглэсэн.


Сүүлийн үеийн судалгааны дүнгээс үзэхэд, И.Тувшинтогтох нэгэн сэдэвт бүтээлдээ (2024) Дагуур-Манжуурын нугажуу хээрийн үргэлжлэл Дорнод Монголд 2 хэсэг (Монгол Дагуур, хянганы салбар уулс) тасархайтан орж ирэх бөгөөд зүйлийн бүрэлдхүүний хувьд ихээхэн ойролцоо болохыг тэмдэглэн, Монголын ургамалжлын талаар шинэ мэдээлэл өгсөн. Энд Зүр өвст (*Filifolium sibiricum*), Алаг өвст (*Hemerocallis minor*, *Vupleurum scorzonrifolium*, *Lespedeza hedysaroides*, *L.juncea*) нугажуу хээрийн хэвшлүүдийг ялгасан нь үүнийг баталж байгаа юм.

Энэхүү өгүүлэлд Сэлэнгийн Дагуурын тойргийн Жидийн районы Дагуурын нугажуу хээрийн ургамал бүргэмдлийн бүрэлдэхүүн ба бүтэцтэй холбоотой онцлог шинжүүдийг танилцуулж байна.

Өмнөд Сибирийн зүүн хэсгийн өвөрмөц онцлог нь Зүүн Ази (Дагуур, Манжуур-Хянган)-ийн гаралтай ургамлын төрөл зүйлийн баялаг олон янз байдалтай холбоотой тухай олон судлаачид тэмдэглэсэн байдаг. Энэ нь санамсаргүй хэрэг биш юм. Зүүн Азийн элементүүд эх газрын гүн рүү нэвтрэн ургамлын аймагт нь шилжин суурьших үйл явц эртний бөгөөд Номхон далай-Алс Дорнодын муссоны нөлөөгөөр тодорхойлогддог (Сочава, 1956; Малышев, Бардунов, 1966). Сэлэнгийн Буриадын ургамалжилд үзүүлэх Алс Дорнодын муссоны нөлөө илэрхий бөгөөд энэ нь Сэлэнгийн цутгал голууд — Хилок, Уда, Чикой, Тэмник, Жид голуудын хөндийн ургамалжлын өвөрмөц ялгаатай байдлаар илэрдэг. Хэдийгээр эдгээр голууд Амарын сав газарт хамаардаггүй ч ургамал бүлгэмдэл нь Дагуур-Манжуурын зүйлүүдээр баялаг, зарим тохиолдолд Хянганы элементүүд ч илэрдэг (Зураг 2; Хүснэгт 1).

Гэсэн хэдий ч Сэлэнгэ хавийн Буриадын нутаг дахь ургамалжлын Дагуурын шинжийг илтгэх ургамлын аймгийн нэмэлт мэдээлэл, ургамал бүлгэмдлийн олон янз байдлын судалгаа хангалтгүй байна. Энэ нь тухайн нутгийн ургамал бүлгэмдлийн олон янз байдал хангалттай судлагдаагүй, мөн ургамалжлын ангиллыг оновчтой хийгээгүйтэй холбоотой. Сэлэнгийн Дагуурын нутагт

Зүүн Азийн нугажуу хээрийн ургамал бүлгэмдэл тархдаг тухай бид 2016 онд Монгол орны нутаг дахь Жид голын сав газар болох Зэлтэрийн хөндийд хийсэн ургамлын аймаг, ургамалжлын судалгааны үр дүн дээр үндэслэн анх удаа мэдээлсэн билээ (Намзалов, 2016). Үүний дараа судалгааг Орос улсын нутагт Жид голын хөндийд үргэлжлүүлэн явуулж, үүний үр дүнд Сэлгэр болон Алцакт орших Дагуурын нугажуу хээрийн хоёр шинэ бүлгэмдлийг илрүүлсэн юм (Зураг 3–5).



Зураг 2. Сэлэнгийн Дагуурын нугажуу хээрийн ургамал бүлгэмдлүүдийн Жид голын хөндий дэх байршлууд:

- Хайлаас бүхий Саман ерхэг- дагуур хошоонбутат (*Agropyron cristatum*, *Lespedeza dahurica*, *Ulmus pumila*) нугажуу хээр – Жид голын Сэлэнгэ мөрөнд цутгадаг орчим, Сэлгэр хэмээх газар оршдог (N50°36' E105°52');
- + Алаг өвс-одой сараанат (*Lilium pumilum*) нугажуу хээр – Жид голын цутгал Зэлтэр голын дэнж (N50°36' E105°12');
- Алаг өвс-бэришт (*Bupleurum scorzoniferolium*) нугажуу хээр – Алцак голын зүүн эрэг дагуух уулсын хормой, Армак голтой нийлэх орчимд байрлана (N50°38' E104°39').



Зураг 3. Зэлтэрийн хөндий дэх Алаг өвс-одой сараанат нугажуу хээр (Монгол улс)



Зураг 4. Жидийн хөндийн Алцак голын дэнж дэх Алаг өвс-бэришт нугажуу хээр (Буриад)



Зураг 5. Хайлаас бүхий Саман ерхөг-дагуур хошоонбутат нугажуу хээр –Сэлгэрийн уулс (Буриад)

Жидийн хөндийн нугажуу хээрийн гурван эталон ургамал бүлгэмдэлд алаг өвс ургамал давамгайлж байгаа нь тодорхойлогдсон. Ургамлын бүрэлдэхүүнд нугажуу хээрийн алаг өвс 25.3%, хуурай хээрийн алаг өвс 7,6%, харин үетний эзлэх хувь 14.0%, улалжийнх 28,6% байв (Хүснэгт 1, 2).

Сөөгнөөс Одой хайлаас (*Ulmus pumila*) ургадаг бол заримдаг сөөгөнцрөөс Агь (*Artemisia frigida*) тэмдэглэгдсэн. Шарилжны энэ зүйл нь голлосон үндэстэй, үржлийн найлзуур босоо, доод хэсэг нь модождог. Ургамал бүлгэмдэлд эзлэх байр суурь харьцангуй сул, арви багатай, голдуу толбо хэлбэрээр тааралддаг. Харин мезоксерофит шинжтэй *Astragalus adsurgens* илүү өргөн тархсан байна (Хүснэгт 1).

№	Зүйл	Ургамал бүлгэмдэл			Ареалын бүлэг/ ургамалжл ын хэвшинж, дэд хэвшинж
		Хайлаас бүхий Саман ерхөг-дагуур хошоонбутат	Алаг өвс-одой сараанат	Алаг өвс- бэришт	
		Географическое положение, позиция в рельефе, ландшафтная приуроченность			
		Жид голын сав газар, Сэлгэр, Буриад	Жид голын сав газар, Зэлтэр голын дэнж	Жид голын сав газар, Алцак голын хөндий	
		N50°36', E105°52'; 762,0 м.	Монгол улс N50°36' E105°12' 787,0 м.	N50°38'005, E104°39'469; 966,0 м.	
		Ерөнхий тусгагийн бүрхэц, %			
		70%.	80%	80-90%	
		Геоботаникийн бичиглэлийн дугаар/өдөр. сар. он			
	№5/26.07.2016	№7/22.07.2006	№1/28.06.2022		
<u>Алаг өвс</u>					
1	<i>Lespedeza davurica</i>	cop1			ВА/П
2	<i>Lespedeza juncea</i>	sp-cop	sp-sol		ВА/П
3	<i>Lilium pumilum</i>	sol	sp-cop		ВА/П ГС
4	<i>Bupleurum scorzonerifolium</i>		sp	cop1	ВА/С П
5	<i>Scabiosa comosa</i>		sp	sp-cop	ВА/ГС П
6	<i>Filifolium sibiricum</i>		sp-sol	sol	МД/П ГС
7	<i>Hemerocallis minor</i>		sol		ВА/ЛС П
8	<i>Allium spirale</i>		sp		МД/П
9	<i>Carum buryaticum</i>			sp	МД/ЛС П
10	<i>Lophanthus chinensis</i>		sol	sp-sol	МД/ГС П
11	<i>Rheum undulatum</i>		sp gr	sp	ЮС/ГС П
12	<i>Saposhnikovia divaricata</i>		sp	sol	ВА/ГС П
13	<i>Adenophora stenanthina</i>			sp	ВА/ЛС
14	<i>Delphinium grandiflorum</i>			sol	МД/ГС П
15	<i>Haplophyllum davuricum</i>			sol	ВА/С П
16	<i>Fornicium uniflorum</i>	sol		sp-sol	ВА/С П
17	<i>Echinops latifolia</i>		sp-sol	sp	ВА/С
18	<i>Cymbaria dahurica</i>		sp-sol		ЮС/ГС
<u>Үетэн ба удалж</u>					
19	<i>Leymus chinensis</i>			sp-cop	ВА/ЛС П

20	<i>Stipa baicalensis</i>		sp		BA/C П
21	<i>Agropyron pectinatum</i>	cop1	sp	sp	EA/C
22	<i>Achnatherum sibiricum</i>	sp			CA/ЛС
23	<i>Cleistogenes squarrosa</i>	sp			OA/C
24	<i>Poa botryoides</i>		sp-cop		BA/ГС П
25	<i>Poa angustifolia</i>			sp	EA/ЛС
26	<i>Koeleria gracilis</i>		sp	sp	BA/C П
27	<i>Carex korshinskyi</i>	sp gr			BA/C
28	<i>Carex praecox</i>			sp	EA/ЛС
<u>Мод. сөөг</u>					
29	<i>Ulmus pumila</i>	sp-sol		sol	ЦА/С
30	<i>Spiraea aquilegifolia</i>		sol		BA/ГС
31	<i>Caragana microphylla</i>	sp gr			МД/С
<u>Заримдаг сөөгөнцөр</u>					
32	<i>Artemisia frigida</i>	sp-sol	sp-sol		EA/ГС
33	<i>Thymus mongolicus</i>	sp			ЮС/ГС
34	<i>Kochia prostrata</i>	sol-un			EA/ГС
35	<i>Astragalus adsurgens</i>		sp	sp	BA/ЛС

Тайлбар:

Ареалын бүлгүүд (АБ): Г – Голарктик; EA – Еврази; CA – Хойд Ази; BA – Зүүн Ази; МД – Манжуур-Дагуур; ЦА – Төв Ази; ЮС – Өмнөд Сибирь-Монгол; OA – Ази.

Ургамалжлын бүс, бүслүүр (ПЗ): СХ – Сийрэг шилмүүст ой; ЛС – Ойт хээр; С – Хээр; П – Нугажуу хээр; ГС – Уулын хээр.

Ургамлын латин нэршлийг “Сибирийн ургамлын аймаг” (1987–1997) бүтээлээс авсан болно.

Зүйлийн арвийг Друдегийн шаталбараар илэрхийлсэн.

Ургамал бүлгэмдэл дэх Алаг өвсний араелын тархацын шинжилгээний үр дүнд (Хүснэгт 1, 2) Зүүн Ази болон Манжуур-Дагуурын зүйл ургамлууд 18 зүйлээс 16 нь буюу 89% -ийг эзлэн давамгайлж байна. Харин зөвхөн хоёр зүйл (*Echinops latifolia*, *Rheum rhabarbarum*) нь илүү өргөн тархацтай, Өмнөд Сибирь–Монголын ургамлын аймгийн төлөөлөл бөгөөд хуурай хээр болон уулын хээрийн бүлгэмдэлд нийтлэг тохиолддог ургамал байна.

Дагуур-Манжуурын гаралтай ургамлуудаас *Filifolium sibiricum*, *Saposhnikovia divaricata*, *Lophanthus chinensis*, *Bupleurum scorzonrifolium*, *Carum buryaticum*, *Adenophora stenanthina* (Пешкова, 2010) зэрэг нь арви өндөртэй ургадагаараа онцлог юм.

Эдгээр зүйлүүд нь Зүүн Азийн муссоны системийн динамик чиг хандлагын таниур болдог. Ямар ч эргэлзээгүйгээр, үүнд дараах ховор, онцгой ургамлууд хамаарна: Баруун Сибирийн Кулундын хээрт олдсон Хависханнавчит бэриш (*Bupleurum scorzonrifolium*), Зүүн Тувагийн өндөрлөгийн хээр хүртэл ургадаг Одой сараана (*Lilium pumilum*), мөн Ангар орчмын ойт хээрийн Алаг өвст хээрт ургадаг Бага хумхаал (*Hemerocallis minor*) (Чернышова нар, 2009).

Ерөнхийдөө ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүнд Зүүн Ази, Манжуур-Дагуур, Өмнөд Сибирь-Монголын зүйлийн төлөөлөл давамгайлж байна — харгалзан 31 / 10 / 9 зүйл. Эдгээрийн дотроос Зүүн Азийн ургамлууд хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд нийт 71 зүйлээс 31 нь Зүүн Азийн гаралтай байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Жид голын хөндий дэх Сэлэнгийн Дагуурын нугажуу хээрийн ургамал бүлгэмдлүүдийн ценофлор дахь ургамал, ареалын бүлгүүд болон ургамалжлын хэвшинжийн харьцаа

Ургамалжлын хэвшинж, дэд хэвшинж	Ургамлын бүлэг, %		Ареалын бүлэг (зүйлийн тоогоор)		
	Алаг өвс	Үетэн ба улалж	Зүүн Азийн	Манжуур-Дагуурын	Өмнөд Сибирь-Монголын
Нугажуу хээр	25,3	14,0			
Хуурай хээр	7,6	28,6			
Бүс, бүслүүр (шт)					
Ойт хээр			4	1	3
Хээр			10	1	1
Нугажуу хээр			12	5	1
Уулын хээр			5	3	4
Нийт	32,9%	42,6%	31	10	9

Дагуурын нугажуу хээрийн ургамлын олон янз байдал нь Сэлэнгийн Буриад болон Дорнод Монголын бүс нутгийг судлаачдын анхаарлыг үргэлж татсаар ирсэн. Энэ бүс нутаг нь ургамлын нөөц, ялангуяа эмийн ургамлын хувьд онцгой баялагаараа ялгардаг. Тиймээс *Scutellaria baicalensis*, *Astragalus mongolicus*, *Saposhnikovia divaricata*, *Bupleurum scorzonerifolium*, *Artemisia adamsii*, *Fornicium uniflorum* зэрэг ургамлуудын эмчилгээний ач холбогдолтой шинж чанаруудыг нээн илрүүлсэн байна (Петухова, 2018; Урбагарова, 2019; Тыхеев, 2020; Рэнцэнбямбаа, 2020).

Гэсэн хэдий ч Буриад дахь эмийн ургамлын төрөл зүйлийн судалгааг өргөжүүлэх, ялангуяа Монголын Сэлэнгийн Дагуурт хамтарсан Орос, Монголын хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх шаардлагатай байна.

(Өгүүлэлд орсон материал нь Оросын Шинжлэх Ухааны Сан болон Буриадын БНУ-ын 24-24-20018 тоот төслийн дэмжлэгтэйгээр бэлтгэгдсэн болно.)

Эшилсэн бүтээл

- Галанин А.В., Беликович А.В., Храпко О.В. 2008. Растительность. Флора Даурии. Том 1. Сосудистые растения. Владивосток: Дальнаука, 14-19.
- Галанин А.В., Беликович А.В. 2012. Восточноазиатская гумидная и Азиатско-Североамериканская аридная ботанико-географические дуги. Наша Ботаничка. Владивосток, URL: http://ukhtoma.ru/geobotany/arc_01.htm
- Камелин Р.В. 1987. Флороценоотипы Монгольской Народной Республики. Ботанический журнал, 72(12): 1580-1594.
- Камелин Р.В. 2002. Важнейшие особенности сосудистых растений и флористическое районирование России. “Проблемы ботаники Южной Сибири и Монголии” Материалы Первой международной научно-практической конференции, 26-28 ноября, Барнаул, Россия: 36-41.
- Камелин Р.В. 2010. Монголия на карте ботанико-географического районирования Палеарктики. Turczaninowia, 13(3): 5-11.
- Колесников Б.П. 1955. Очерк растительности Дальнего Востока. Хабаровск: Хабаровское книжное изд-во, 104.
- Королюк А.Ю. 2002. Растительность. Степи Центральной Азии. Новосибирск: Изд-во СО РАН, 45-94.
- Куренцова Г.Э. 1962. Растительность Приханкайской равнины и окружающих предгорий. М.-Л.: Изд-во АН СССР, 139.
- Мальшев Л. И., Бардунов Л. В. 1966. География притихоокеанских флористических элементов Восточной Сибири (в связи с миграциями и эволюцией флор в бассейне Тихого океана). Доклады Института географии Сибири и Дальнего Востока. 12: 47-51.
- Намзалов Б.Б. 2016. О растительности долины Дзэлтэра и ее месте в ботанико-географическом районировании (бассейн р. Селенга, Монголия). Воспоминания о совместной экспедиции с Р. В. Камелиным. Turczaninowia, 19(4):40-46.
- Петухова С.А. 2018. Фармакогностическое исследование Володушки козелецелистной (*Vupleurum scorzonerifolium* Willd.) травы и разработка на ее основе экстракта сухого. Автореф. дис. канд. фарм. наук. Улан-Удэ, 22.
- Пешкова Г.А. 2010. Даурская лесостепь (состав, особенности, генезис). Барнаул: АРТИКА. 144.
- Рэнцэнбямбаа С. 2020. Фаркогностическая характеристика *Artemisia adamsii* Bess. и *Artemisia macrocephala* Jaque. ex Bess. Флоры Бурятии и Монголии и разработка лекарственных средств на их основе. Автореф. дис. канд. фарм. наук. Улан-Удэ, 23.
- Сочава В.Б. 1956. Закономерности географии растительного покрова горных тундр СССР. Академику В.Н. Сукачеву к 75-летию со дня рождения. М.-Л.: Изд-во АН СССР, 522-536.
- Сочава В.Б., Липатова В.В. 1960. Группировки степных растений в амурской подтайге. Тр. Моск. об-ва испыт. природы, 3. 263-276.
- Түвшинтогтох И. 2024. Дорнод монголын урагамалжил (ангилаа, зураглал, доройтол, өөрчлөгдөл). Улаанбаатар: Адмон принт, 540.

- Тыхеев Ж.А. 2020. Фармакогностическое исследование растений рода *Vireum* L. регионов Внутренней Азии: Автореф. дис. канд. фарм. наук. Улан-Удэ, 23.
- Урбагарова Б.М. 2019. Фармакогностическое исследование Сапожниковии растопыренной (*Saposhnikovia divaricata* (Turcz.) Schischkin) корней и разработка на их основе экстракта сухого: Автореф. дис. канд. фарм. наук. Улан-Удэ, 22.
- Чернышева О.А., Плешанов А.С., Верховина А.В. 2009. Ландшафтное распределение реликтовых сосудистых растений в Верхнем Приангарье. Проблема и стратегия сохранения биоразнообразия растительного мира Северной Азии: Матер. Всерос. конф. Новосибирск: ЦСБС СО РАН, 264-265.
- Шатилина Т.А., Анжина Г.И. 2011. Изменчивость интенсивности дальневосточного муссона в 1948- 2010 гг. Известия ТИНРО. 167:146-159.

About some unique plant communities of the Daurian meadow steppe, spread in the valley of the Jid River in Selenga (Buryatia - Mongolia)

Bimba-Tsyren Batomunkuevich Namzalov^{1*}, Indree Tuvshintogtokh²,
Maksar Bimba-Tsyrenovich Namzalov¹

¹Department of Botany, Buryat State University, Ulan-Ude, Russia
Botanic Garden and Research Institute, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar 13330, Mongolia

*E-mail: namzalov@rambler.ru

Abstract: The territory of the Selenga Middle Mountains in southern Buryatia and the northern part of Mongolia, adjacent to the Amur River basin, belongs to the Daurian-Manchurian province of the East Asian sub-kingdom of the Holarctic according to floristic zoning. The monsoon influence penetrates deeply inland along the Amur basin, reaching the Selenga Dauria, which is reflected in the rich vegetation diversity of the Selenga tributaries — the Khilok, Chikoy, and Dzhida rivers. Fragments of meadow steppe (prairie) vegetation are recorded in the lower reaches of the Dzhida valley, represented by three landscape-phytocoenotic refugia: Selger, Dzelter, and Altsak. Typical species of the prairie floristic complex include *Bupleurum scorzonerifolium*, *Scabiosa comosa*, *Filifolium sibiricum*, *Lespedeza davurica*, *Saposhnikovia divaricata*, *Lilium pumilum*, and *Delphinium grandiflorum*. In only three prairie communities of the Dzhida valley, a total of 71 species of vascular plants have been recorded, with the forb fraction accounting for 25.3% of the total species composition, and East Asian and Daurian-Manchurian species comprising 89.0%. This rich gene pool of Daurian prairie vegetation is manifested in the wealth of plant resources, especially medicinal plants.

Keywords: Selenga Dauria, meadow steppe plant community, medicinal plants

© The Author(s). 2025 Open Access This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and source, provide a link to the Creative Commons license, and indicate if changes were made.